

Хичээл эхлэхийн
өмнө сурах бичиг,
дэвтэр, үзгээ бэлдэн
дэлгэцдээ ойртон
суугаарай.



Эхээс чухал хэсгийг
олж, бичигчийн санааг
тайлбарлах



Чаплины охиндоо илгээсэн захидал

Охин минь, өнөөдөр зул сарын баяр. Дүү нар чинь аль хэдийн унтчихсан. Ээж чинь ч унтжээ.

Надаас хэдий хол байвч дүр төрх чинь үргэлж хажууд минь байх юм.

...Би бол чиний эцэг, би бол Чарли Чаплин... Өдгөө аав нь хөгширчээ. Өнөөдөр чиний үе ирж, бүжиглэ, охин минь. Аав нь уранхай өргөн өмдтэй бүжиглэж байсан бол чи минь торгон даашинзтай бүжиж байна. Чиний бүжиг, үзэгчдийн алга ташилт чамайг тэнгэрт дүүлэн нисгэх болно. Дүүлэн нис охин минь. Гэхдээ газарт бас буухаа мартуузай. Хүмүүсийн амьдралыг мэдэж байх ёстой шүү. Чи минь өлсөж ундаассан, даарч бээрсэн, гудамжны бүжигчдийн амьдралыг мэдэх учиртай. Би яг л тэдэн шиг байсан.

... Би өлсөхийн зовлон, орох оронгүйн зовлонг амссан. Түүгээр ч барахгүй бардам сэтгэл минь хүмүүсийн шидэх зоосонд дарагдаж өр өвдөж явсан. Гэсэн ч би амьд үлдсэн юм шүү.

...Охин минь, энэ хорвоод дуу бүжгээс өөр зүйл бас байдаг юм шүү. Үдэш тайзнаасаа буухдаа чинээлэг шүтэн бишрэгчдээ мартаж болох ч гэрт чинь хүргэж өгөх таксины жолоочоос эхнэрийнх нь тухай асуухаа битгий мартаарай. Эхнэр нь жирэмсэн, хүүхдийн живхний мөнгөгүй бол халаасанд нь мөнгө хийгээрэй. Хааяа ч гэсэн хотоор алхаж ядуу зүдүү тарчиг амьдралтай хүмүүсийг харж бай. Урлаг хүмүүст дүүлэн нисэх даль жигүүр хайрладаг хэрнээ хөлийг нь хугалж хаядаг жамтай. Охин минь, өөрийгөө үзэгчдээс дээгүүр мэт санасан тэр өдрөө тайзаа орхиорой. Парис хотын зах руу явж өөр шигээ бүжигчдийг хар. Тэдэн дундаас чамаас илүү авьяастай нь ч таарна. Өөрийгөө бүү хуур.

...“Чамайг хангалуун амьдраасай” гэж би хүсэж байна. Гэхдээ охин минь, 2 франкийг өөртөө, 3 дахийг нь бусдад зориулж байгаарай. Аав нь циркэд олон жил ажилласан шүү дээ. Олсон дээр явагчдын өмнөөс их л санаа зовдог байлаа. Гэхдээ хүмүүс олсон дээр явагчдаас илүү газраар явахдаа хөл алддаг даа.

... Чиний судсаар миний цус гүйж байгаа. Би сахиусан тэнгэр шиг ариун байгаагүй ээ. Гэхдээ би хүний энтэй хүн байхсан гэж хичээж амьдарсан. Чи минь бас ийм байхыг хичээгээрэй.

Үнсье охин минь.

1965 оны 12 сар

Захидалд юуны тухай өгүүлж байна вэ?

- Аав нь охиндоо сургамж хайрлаж байгаа тухай.
- Аав нь охиноо үргэлж хайрлаж явдгаа өгүүлж байгаа тухай.
- Аав нь охиноо амьдралыг зөвөөр харж явахыг сургамжилсан тухай.
- Аав нь охиндоо өөрийгөө болон бусдыг хайрлахыг ухааруулсан тухай

Захидлын түлхүүр үгсийг ашиглан гол санааг олж бичээрэй.

- Хүн өөрийн амьдралыг, мөн хүн хүнээ хайрлаж байх хэрэгтэй.
- Хүнийг ялгаварлан харьцаж гадуурхаж болохгүй.
- Ахмадын сургаалыг сонсож, биелүүлж явах хэрэгтэй.
- Хүн хүсэл тэмүүлэлтэй, зорилготой, сайхан сэтгэлтэй амьдрах хэрэгтэй.

Чаплины охиндоо хэлсэн захиасуудыг түүж бичээд бичигчийн санааг таамаглан тайлбарлаарай.

Чаплины охиндоо хэлсэн захиас нь:

- ✓ Гоо үзэсгэлэнгээ гайхуулан бүжиглэ, охин минь. Од болон гялалз, охин минь
- ✓ Урлаг хүнд дүүлэн нисэх жигүүр хайрладаг хэрнээ хөлийг нь хугалж хаядаг жамтай.
- ✓ Дүүлэн нис охин минь, гэхдээ газарт буухаа мартуузай.
- ✓ Хүмүүсийн амьдралыг мэдэж байх учиртай шүү.
- ✓ Зүрх сэтгэлээ очир эрдэнэсээр бүү соль.

- Хүсэл мөрөөдлийхөө төлөө тууштай, шантралгүй яваарай.
- Ажил амьдралаа үргэлж тэнцүүлж байгаарай.
- Амжилтадаа хөөрч дэвэрч болохгүй.
- Хүнд тус дэмтэй яваарай.
- Эд хөрөнгийн төлөө хэтэрхий хөөцөлдөж болохгүй, амьдралд хөл алдана шүү.

Чаплин охиндоо захиж бичсэн ихэнх өгүүлбэрээ дараах байдлаар төгсгөжээ.
Эдгээр өгүүлбэрийн төгсгөлүүд ямар утга илэрхийлж байна вэ?

- ✓ Гэхдээ хүмүүс олсон дээр явагчдаас илүү газраар явахдаа хөл **алддаг даа**.
- ✓ Дүүлэн нис охин минь, гэхдээ газарт буухаа **мартуузай**.
- ✓ Хүмүүсийн амьдралыг мэдэж байх **учиртай шүү**.
- ✓ Зүрх сэтгэлээ очир эрдэнэсээр **бүү соль**.
- ✓ Од болон **гялалз**. **Охин минь**
- ✓ Охин минь, өөрийгөө үзэгчдээс дээгүүр мэт санасан тэр өдрөө тайзаа **орхиорой**.

- Бичигчийн санааг илүү тодруулсан байна.
- Анхааруулж сануулсан
- Хүч нэмэгдүүлэн эрчимжүүлсэн.
- Ухааруулж бодуулсан
- Охины өмнөөс хүсэн мөрөөдсөн.
- Ерөөн хүссэн утга түлхүү илэрсэн байна.

Гэрийн даалгавар

“Сайн номыг дэлгэсэн
цагаас жинхэнэ ид шид
тохиож эхэлдэг гэдэгт
би үргэлж итгэдэг ”

Ж.К.Роулинг

